

Ч. Чойсамба

ОРЧИН ҮЕИЙН ТОГТМОЛ ХЭВЛЭЛИЙН ЯРИЛЦЛАГЫН ГАРЧГИЙН ОНЦЛОГ

Гарчгийг нэгэн судлаач «уншигчдыг сонин сэтгүүлийн агуулга руу хандуулах луужин» гэж оновчтой дүрслэн тодорхойлсон нь бий. Үнэхээр хүн бүр дуудуулах нэртэй байдгийн адил сонины нийтлэл болгон өөрийн гарчигтай байдаг. Хамгийн энгийнээр хэлэхэд гарчиг бол нийтлэлийн нэр юм. Үүнийг дэлгэрүүлвэл, нийтлэлийнхээ агуулгыг ямар нэг хэмжээгээр илэрхийлсэн, уншигчийн сонирхлыг татахуйц товч мэдээлэл билээ.

Сүүлийн үед хязгаарлагдмал уншигчдын төлөө хязгааргүй олон сонины хооронд ширүүн, зарим талаар бүтээлч өрсөлдөөн өрнөсөн нь гарчгийн ач холбогдлыг улам нэмэгдүүлжээ. Гарчиг бол нийтлэлийнхээ талтай тэнцэхүйц мэдээлэл гэдэг нь оргүй хоосон үг биш юм. Чухамдаа гарчиг л уншигчдын нүдэнд юуны түрүүнд тусч, тэдний оюун санааг эргэлт буцалтгүй эзэмддэг. Тухайлбал: урьд нь «Хүн амины хэрэг гарлаа» гээд энгийн, товчхон гарчигладаг байсан бол өдгөө уншигчдын анхаарлыг татаж, сониноо гүйлгэхийн тулд «Онцгой хэрцгийгээр хүний амь бүрэлгэжээ», «Гиннесийн номонд орохуйц хүн амины онц ноцтой хэрэг гарлаа», «Гэмт хэргийн ертөнцөд урьд өмнө тэмдэглэгдэж байгаагүй аймшигт аллага» гэх мэтээр сүржин гарчиглах болов.

Сүүлийн жилүүдэд хамгийн түгээмэл болсон бичлэгийн төрөл, зүйл бол ярилцлага гэдэгтэй санал зөрөх хүн гарахгүй биз ээ. Одоогоос ердөө 20-30 жилийн өмнө манай төвийн хэвлэлүүдэд нэг дугаарт нэг үзэгдэхтэй үгүйтэй байсан ярилцлага өдгөө аль ч сонинд бөөн бөөнөөрөө нийтлэгдэх болжээ. Нэг дугаарт том, бага хэмжээний 5-16 ярилцлага хэвлэгдэж, ашигтай талбайн (үүнд реклам сурталчилгаанд зориулсан талбайг оруулаагүй болно) 50 хүртэл хувийг эзгнэсэн нь бичлэгийн бусад төрөл, зүйл «Улаан ном»-онд орж гэлтэй.

Ярилцлагын гарчиг бичлэгийн бусад төрөл, зүйлийн гарчгийг бодвол онцлогтой. Энэ нь юуны түрүүнд ярилцлагын өөрийнх нь мөн чанартай холбоотой. Ярилцлага бол сэтгүүлч, ярилцагч хоёрын дундын бүтээл юм. Тиймээс ярилцлагадаа гарчиг өгөхдөө сэтгүүлч ихэнхдээ хоёр аргыг хэрэглэдэг. Эхнийх нь сэтгүүлч ярилцагчийн хариултад тулгуурлан гарчгийг өөрийн үгээр өгдөг. Хоёр дахь нь хамгийн түгээмэл бөгөөд сэтгүүлч ярилцагчийн хэлсэн үгнээс иш татах юм. Ярилцлагаас бусад бичлэгийн төрөл, зүйлд сэтгүүлч гагцхүү өөрийн үзэмжээр гарчиг өгдөг.

Мэдээж, 2-3-хан асуултаас бүрдсэн бичил ярилцлагаас авахуулаад нүүр дамжсан ярилцлаганаас нэг санааг гогцоодон авч, гарчиг урлах нь амаргүй ажил. Магадгүй, энэ нь ярилцагчийн мөн чанарыг дэлгэн харуулах чадвартай сонирхолтой асуулт олж сэдэхээс ч хэцүү байж болно. Тэгвэл ярилцагчийн хэлсэн ямар санаа гол төлөв гарчигт орж байна вэ? Энэ асуултанд хариулахын

тулд бид тогтмол хэвлэлийн ярилцлагын гарчгийн агуулгыг задлан шинжлэхдээ юуны өмнө дараах шалгуурыг тавьсан болно. Эн түүнд манай хэвлэлд цөөнгүй үзэгддэг зохиомол, эсвэл ярилцагч нь тодорхойгүй, үнэн худал нь мэдэгдэхгүй ярилцлагыг судалгаанд хамруулсангүй. Түүнчлэн борлогддог хувиараа ч, уншигддаг хүрээгээрээ ч манай томоохон сонинд тооцогддог хэвлэлүүдийг бид эмпирик хэрэглэгдэхүүн болгов.

Энгийн нэг санааг гарчигт оруулах нь ашиггүй. Энэ нь уншигчдын анхаарлыг татахгүй өнгөрнө. Ингэх нь сонины хувьд бөөн алдагдлаар эргэх уршигтай. Учир нь чөлөөт, чөдөртөй, хар, шар, улаан хэвлэлийн нийтлэлүүдэд арван жилийн турш бөмбөгдүүлсэн, нүдүүлсэн манай уншигч сүүлийн үед хэр баргийн юм тоож уншихаа больсон. Тиймээс хамгийн этгээд, хамгийн хачирхалтай, хамгийн гаж, хамгийн итгэмээргүй зүйл гарчиг руу өөрийн эрхгүй «тэмүүлэв». Энэ «хамгийн» гэх тодотголтой бүхэн сэтгүүлчийн гарыг дамжин хоёр замаар гарчиг болон хувирч байна. Эхнийх нь сэтгүүлчийн оролцоог төдийлөн шаардахгүй бөгөөд сэтгүүлч зөвхөн ярилцагчийн аль нэг санааг онцолно. Нэгэн ярилцлагын гарчгийг сонирхёе. «Авилгын гишүүн», «Казино» хэмээн олноо алдаршсан Д. Энхбаатартай шоронгийн амьдралын тухай хийсэн ярилцлагыг сэтгүүлч «Бэлэг эрхтнээс нь бакаал уяад гэдсэн дээр нь тавьчихдаг юм» гэжээ. Ер нь бэлэг эрхтэнтэй, секстэй холбоотой бүхэн л ногоон гэрлээр гарчигт орж байх жишээтэй. Энэ талаар хэдэн гарчиг дурдъя.

«Аттила» баарны тайчигч Г. Туяа: «Сексийн сайхныг юутай ч зүйрлэхгүй, хамгийн гоё, гайхамшигтай зүйл» («Дээдсийн амьдрал». 2001. № 27, 28.).

Яруу найрагч Р. Эмүжин: «Сексийг эрэгтэй, эмэгтэй хүнтэй ямар ч хэлбэрээр, яаж ч хийж болдог» («Дээдсийн амьдрал». 2001. № 25, 26.).

Т. Саран: «Надтай секс хийнэ гээд чадал нь хүрэх юм бол "пожалуйста"» («Дээдсийн амьдрал». 1999. № 07, 08.).

MN-25 телевизийн хөтлөгч М. Халиуны ээж, Ерөнхий сайд асан Р. Амаржаргалтай амьдарч байсан жүжигчин Р. Гэрэл: «Амараа гайхамшигтай сексддэг учраас би салдаггүй байсан» («Дээдсийн амьдрал». 2001. № 51, 52.).

Загвар өмсөгч Л. Эрдэнэсүвд: «Миний сэрэл хөхөндөө байдаг. Сексийн хувьд гоё "унтдаг" хүнтэй таараагүй явна» («Дээдсийн амьдрал». 2001. № 07, 08.).

Ярилцагч зүгээр байж байгаад иймэрхүү зүйл ярьчихгүй нь тодорхой. Сэтгүүлчид ярилцлага авахдаа юу гэж асуугаад гарчиг өгөх вэ? гэдгээ урьдчилаад шийдчихсэн байдаг гэж дээрх гарчгуудыг хараад баттай хэлж болно. Тэдний хувьд бусад асуулт төдийлөн ач холбогдолтой биш юм.

Сексээс гадна хэн нэгнийг эвгүй байдалд оруулсан, гаргасан алдаа дутагдлыг нь ухааж төнхсөн, өнгөрснийг нь уудалсан зүйл байвал мөн л гарчиг болох баталгаатай. Жишээлбэл: *УИХ-ын гишүүн М. Зэнээгийн анхны эхнэр, 4 хүүхдийнх нь ээж Г. Хүрэлдээ: «Зэнээ архинд орж, намайг зодоод зогсоогүй,*

сэтэрхий уруултай гэж хүүхдээ ад үзсэн» («Монголын нэг өдөр». 2001. № 7.), Яруу найрагч Р. Гэрэл: «Р. Амаржаргал эр хүний хувьд хувиа бодомтгой шүү дээ» («Шар сонин». 2001. № 44.) г. м.

Хүний тухай биш, өөрийнхөө тухай ярьж байхдаа анхааралтай байхгүй бол горьгүй. Хазгай гишгэсэн алхам, хальтирч хэлсэн үг бүхэн таны эсрэг факт болно гэдгийг мартаж өсгүй. Нэг ярилцлагыг *FM-107-ийн хөтлөгч Г. Ууганцэцэг: «Намайг чихрийн мангас гэдэг» («Дээдсийн амьдрал». 2001. № 27, 28.)* гэсэн байх юм. Ярилцагчийн хэлсэн олон санаанаас гагцхүү үүнийг товойлгосон нь гайхалтай. Ярилцагчаа уншигчдынхаа өмнө эвгүй байдалд оруулах гэж ярилцлага хийдэггүй баймаар. Гэтэл үгүй ээ. Ёстой л ашигласан бол сэтгүүлчийн зол, ашиглуулсан бол тэр хүний хохь гэдэг хууль үйлчилж байна гэлтэй.

Өөр нэг жишээ үзье. «Зууны манлай дуучин» Б. Сарантуяа нөхөр Л. Болдхуягаас салсны дараа өгсөн ярилцлагыг Б. Сарантуяа: *«Би одоо ч гэсэн нэг сайхан шар залууг таврээд хэвтэж байна» («Монголын нэг өдөр». 2001. № 38.)* гэж гарчиглажээ. «Поп хадагтай» маань дахиад гэрлэлтээ цуцлуулсан ч эрийн тэнгэртэй, эрчүүдээр дутагдахгүй одонд төрж гэж бодогдмоор. Ингээд ярилцлагыг уншвал:

Сурвалжлагч: - *Тэгэхээр яг одоо ийм үед танд ханийн хайр халамж үгүйлэгдэхгүй байна гэж үү?*

Б. Сарантуяа - ... *Хамгийн гол нь би гэр бүлгүй хоосон өвдгөө тэврээд хэвтэж байна гэвэл эндүүрэл шүү. Би бас нэг хөөрхөн шар залуу тэврээд хэвтэж байгаа ш дээ. Ерөөсөө л нөхрийнхөө канондсон хувилбарыг тэвэрч байна гэсэн үг. Тэгээд салсан нөхрөө санах юм бол хүү маань миний хажууд байна гэж хариулжээ. Энэ тохиолдолд сэтгүүлч үгийн наадаан хийж, уншигчдыг чулуу хөөлгөсөн байна. Учир нь Б. Сарантуяагийн шинэ амрагийн тухай сонирхох гэсэн уншигч тэр шар залуу нь хүү нь юм байна гэдгийг ойлгож, «урам нь хугарах» юм.*

Ийм нэг яах аргагүй сенсаци гарчгийг үзье. *СТА жүжигчин Ж. Сүххуяг: «Би одоо Авдрантын хориход ял эдэлж байна» гэжээ («Дээдсийн амьдрал». 2001. № 33, 34.).* Туршлагагүй уншигч сэтгүүлчийн урхинд орж, Сүххуягийг сүүлд архинд орсон, зах дээр юмаа зарж байна гээд л бичээд байсан, нээрээн энэ чинь юу болчихсон юм бэ? гэж гайхаж болно. Гэтэл... Ярилцлаганаас сонирхуулъя:

Сурвалжлагч: - *Та сүүлийн үед нэг л харагдахгүй байх шиг. Юу хийж байна даа? Өөрийнхөө сүүлийн үеийн сонин сайхнаас сонирхуулаач.*

Ж. Сүххуяг: - ... *«Эзэнгүй айл» кино маань ч эхлээгүй байна. Би үсээ авахуулчихаад хүлээгээд байдаг. Одоо би чинь Авдрантын шоронд ял эдэлж байгаа шүү дээ, тэгээд гараад яахыг маань найруулагч л мэдэх байх даа.*

Мөн л сэтгүүлчийн ээлжит урхи. Жүжигчин Ж. Сүххуяг киноны зураг авалтын тухай ярьсныг сэтгүүлч шууд бичсэнээр яг бодит амьдрал дээр болж буй мэт болжээ.

Хоёр дахь арга нь сэтгүүлчээс багагүй заль мэх шаардана. Өдөөр зэвсэглэсэн сэтгүүлч ингэснээр бяраар бялхсан бөхийг ч төвөггүй тонгорно. Эл аргын талаар хэдэн үг хэлье. Уншигчийг «лантуудах» мэдээлэл гаргахын тулд сэтгүүлч ярилцагчийн хэлсэн зүйлийг хасч нэмж, өөрийн үгээр тайлбарлаж, эцсийн дүнд ярилцагчийн хэлээгүй санааг гартал засварлаж, мэс ажилбар хийдэг. Гагцхүү мэс ажилбар нь үзэгний тусламжтай хийгддэгээрээ онцлог.

«Аттила» баарны тайчигч бүсгүй Г. Баяртуяа: «Манай захирал Л. Гүндалай крем, хувцас авч өгч, амралт зугаалганд хамт явцгаадаг» гэсэн гарчгийг уншихад хэн ч Г. Баяртуяа эрхэм гишүүн Л. Гүндалайтай ажил олгогч-ажилтны хүрээнээс хальсан зүй бус харьцаатай юм байна гэж ойлгоно. Ингэж ойлгохоос ч өөр аргагүй юм. Гэтэл ярилцлагыг уншихад:

Сурвалжлагч: - *Та нарын хангамж хэр сайн бэ?*

Г. Баяртуяа: - *Манай баарны удирдлагаас бид нарт крем, хувцсыг цаанаас тавьж өгдөг. Бас манайхан бүгдээрээ амралт зугаалганд явдаг гэж хариулсан байх юм.* («Дээдсийн амьдрал». 2000. № 55, 56.)

Л. Баянхүүгийн ээж Галина: «Оюунтуяа Германд очоод саваа авахуулсан. Тэр одоо эмэгтэй хүн биш болсон» гарчгийг уншихад «Монголын мистер» Л. Баянхүүгээс салж, баян германтай амрагийн харьцаанд орсон гэж хэвлэлээр шуугиулсан «Монголын сайхан бүсгүй» Б. Оюунтуяад хуучин хадам нь хорсож, зэвүүцэж байна гэж ойлгоно. Ер нь эх хүн эмэгтэй хүний тухай маш эвгүйгээр хэлжээ. Тэгтэл ярилцлагад ийм санаа байхгүй бөгөөд Л. Баянхүүгийн ээж: «Сүүлд нөгөө захиан дээрээ бичсэнээр бол {Оюунтуяа} Германд саваа авахуулсан гэж байсан. Энд байхдаа ч гэсэн хүүхэд гаргаж болохгүй байсан юм шиг байна лээ. Одоо тэгэхээр дахин хэзээ ч хүүхэд гаргахгүй гэсэн үг биз» гэснийг сэтгүүлч хачирлаж, гал авалцуулжээ. («Монгол төрх». 2001. № 5.)

Хэрэв гарчиг болгочихоор зүйл ярилцлагад байхгүй бол сэтгүүлч зориуд ухаж гаргана. Үүний тулд нэг их ухаан зараад байх шаардлага үгүй. Хүний хэлсэн ямар ч зүйлээс тодорхой нэг санааг нь хасчихвал огт өөр, хэлэх гээгүй утга гардаг. Нэг ярилцлагыг үзье. «Сайхан бүсгүй-99» тэмцээний Сувд эрдэнийн өргөмжлөлт бүсгүй сурвалжлагчид ярилцлага өгөхдөө «Хэнийг хүндэлдэг вэ?» асуултанд «Ээжийгээ хүндэлдэг. Ээж маань намайг хэний ч өмнө нүүр улайлгахгүй явуулж байгаад нь баярладаг. Өөрөөр хэлвэл би ээждээ их өртэй хүн болж байгаа юм даа» гэжээ. Сүүлийн өгүүлбэрээс ердөө «ээждээ» гэдэг үгийг хасаад, гарчигт оруулчихад л сенсацитай материал бий болчихож байгаа юм. «Энэ мисс чинь яагаад, хэнд өртэй юм бол?» гэж уншигчийн сонирхол өдөөгдөх нь ойлгомжтой. «Би их өртэй хүн» гэж «хэрчмэл» хэлбэрээр гарчигласан нь ярилцагчийн хэлэх гээгүй санааг агуулснаараа «хорлонтой» болсон юм. Өөрөөр хэлвэл, ярилцагч энд сэтгэл санааны асуудлыг хөндсөн

байхад сурвалжлагчийн «мэс засал»-ын үр дүнд тэрээр санхүүгийн гүн хямралд орсон, бараг ивээн тэтгэгч хайж буй мэт сэтгэгдэл уншигчдад төрүүлэхээр болжээ.

Энэ бүхнийг бид сэтгүүлчдийг буруутгах гэж бус, тэднээс ам асуух гэж бус, гагцхүү судалгааны зорилгоор өгүүлсэн болно.